



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

155.	Зээлийн батлан даалтын сангийн тухай	510
156.	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	517
157.	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	517
158.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	518
159.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	518
160.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	519
161.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	519

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

162.	Улсын Их Хурлын 2012 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 14	520
163.	Бор-өндөр сум байгуулах тухай	Дугаар 15	521
164.	“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 18	524
165.	Тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай	Дугаар 19	524
166.	Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 20	525
167.	Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай	Дугаар 21	526



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 168. | “Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр” батлах тухай | Дугаар 370 | 526 |
| 169. | Талбайг нөөцөд авах тухай | Дугаар 372 | 538 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 170. | Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 02 | 547 |
|------|--|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж

2.1.Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², энэ хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

¹Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар Засгийн газар үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч болон давхар батлан даагчаар орж байгаа зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл.Зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн байдал

4.1.Зээлийн батлан даалтын сан /цаашид “Сан” гэх/ нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“жижиг, дунд үйлдвэр эрхлэгч” гэж Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн³ 5.1-д заасан этгээдийг;

5.1.2.“батлан даалт” гэж Иргэний хуулийн 458 дугаар зүйлд заасныг;

5.1.3.“зээлийн батлан даалт” гэж Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн⁴ 28 дугаар зүйлд заасныг;

5.1.4.“жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” гэж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн⁵ 6.4.4-т заасныг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ САНГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6 дугаар зүйл.Санг үүсгэн байгуулах

6.1.Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэн, хуулийн этгээд Сангийн үүсгэн байгуулагч байж болно.

³Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 32 дугаарт нийтлэгдсэн.

⁴Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

⁵Засгийн газрын тусгай сангийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



6.2. Үүсгэн байгуулагчдын анхны хурлаар Сангийн дүрмийг батлах бөгөөд Сангийн дүрмийг баталснаар Санг үүсгэн байгуулсанд тооцно.

7 дугаар зүйл. Сангийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт

7.1. Сан нь удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирал, зээлийн батлан даалтын хороотой байна.

7.2. Сан нь энэ хуулийн 7.1-д зааснаас гадна зохион байгуулалтын бусад бүтэцтэй байхаар дүрэмдээ зааж болно.

7.3. Сангийн удирдах дээд байгууллага нь Удирдах зөвлөл байх бөгөөд үүсгэн байгуулагчдын хурлаас Сангийн дүрэмд заасны дагуу Удирдах зөвлөлийн гишүүдийг томилно.

7.4. Сангийн үүсгэн байгуулагчдын анхны хурлаас Сангийн дүрмийг баталж, Удирдах зөвлөлийн гишүүдийг томилсны дараа үүсгэн байгуулагчдын энэхүү эрх нь Удирдах зөвлөлд шилжих бөгөөд Сангийн дүрэмд Удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.5. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь төсөв, санхүүгийн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөрөнгө оруулагч, хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ.

7.6. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Сангийн үйл ажиллагаатай шууд холбоотой этгээдийн төлөөллийг оруулж болно.

8 дугаар зүйл. Сангийн дүрэм

8.1. Сангийн дүрэмд дараах зүйлийг тусгана:

8.1.1. нэр, хаяг байршил;

8.1.2. зорилго;

8.1.3. үйл ажиллагааны чиглэл, зарчим;

8.1.4. удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналтын тогтолцоо, эрх бүхий этгээдийг томилох, чөлөөлөх журам;

8.1.5. Удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын бусад бүтцийн эрх хэмжээ, чиг үүрэг;

8.1.6. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гаргах журам.

8.2. Сангийн дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахад Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

9 дүгээр зүйл. Сангийн үндсэн үйл ажиллагаа

9.1. Сан нь дараах үйл ажиллагааг явуулна:

9.1.1. Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах;

9.1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн⁶ 5.1-д заасны дагуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээс гаргасан хаалттай өрийн бичгээс банк, санхүүгийн байгууллага худалдаж авсан бол уг худалдаж авсан өрийн бичигт батлан даалт гаргах.

9.2. Сан нь энэ хуулийн 9.1.1-д заасан батлан даалтыг гаргахдаа тухайн зээл олгох банк, санхүүгийн байгууллагын дүгнэлтэд үндэслэнэ.

9.3. Сангийн хөрөнгийг банкинд хадгаламж, харилцах хэлбэрээр болон Засгийн газрын өрийн бичиг, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад хэлбэрээр байршуулж болно.

10 дугаар зүйл. Бусад үйл ажиллагаа

10.1. Сан нь үндсэн үйл ажиллагаагаатайгаа холбогдуулж дараах бусад үйл ажиллагааг явуулна:

10.1.1. зээлийн мэдээлэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хариуцсан эрх бүхий байгууллага, шаардлагатай бусад төрийн болон хувийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, лавлагаа авах;

10.1.2. зээлийн батлан даалт болон холбогдох бусад үйл ажиллагаанаас бий болсон хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулах зорилгоор тэдгээрийг бусдад худалдах, хуулиар зөвшөөрсөн бусад арга хэмжээг авах.

11 дүгээр зүйл. Сангийн үйл ажиллагааны журам

11.1. Удирдах зөвлөл Сангийн үйл ажиллагааны дараах журмыг батална:

⁶Үнэт цаасны зах зээлийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.



11.1.1. батлан даалтын төрөл, хэмжээ, хугацаа, хураамж, шимтгэл, бусад нөхцөл;

11.1.2. батлан даалт гаргах журам;

11.1.3. батлан даалтаар хүлээсэн үүрэг гүйцэтгэх журам;

11.1.4. батлан даалт гаргах үйл ажиллагааны хүрээнд банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах журам;

11.1.5. Сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам;

11.1.6. бүртгэл, мэдээллийн хадгалалтын журам.

11.2. Сангийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас давхар батлан даахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.

12 дугаар зүйл. Батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамж

12.1. Сан нь үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хураамж авах бөгөөд батлан даалтын шимтгэл, хураамжийн хэмжээг Сан тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ

13 дугаар зүйл. Засгийн газар, түүний харьяа байгууллагын оролцоо

13.1. Сангийн хүсэлтээр сангийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас Санд нэмэлт санхүүжилт, хөнгөлөлттэй зээл олгож болно.

13.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сангийн гаргасан нийт батлан даалтын 60 хүртэл хувийг давхар батлан даана.

13.3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь тухайн жилд Сангийн гаргахаар төлөвлөсөн нийт батлан даалтын дүнгийн 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг болзошгүй өр төлбөрийг нөхөхөд зориулан бэлэн мөнгө хэлбэрээр дансандаа байршуулна.



13.4.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас гаргах давхар батлан даалтын шимтгэл, үйлчилгээний хөлсийг Сантай зөвшилцөж, жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ САНГИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, БҮРТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

14 дүгээр зүйл.Сангийн өөрийн хөрөнгө

14.1.Сан үйл ажиллагаагаа явуулахад хүлээх үүргийн баталгаа болгох зорилгоор өөрийн хөрөнгөтэй байна.

14.2.Сангийн өөрийн хөрөнгийн доод хэмжээг болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

14.3.Сангаас гаргах батлан даалтын нийт хэмжээ нь Сангийн өөрийн хөрөнгийг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.

14.4.Сангийн үйл ажиллагааны зохистой харьцаа Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгийн хэмжээндээ хувь тэнцүүлэн дахин хөрөнгө оруулж өөрийн хөрөнгийн дутууг нөхөх саналыг Сан тавьж болно.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасан саналыг хөрөнгө оруулагч хүлээж аваагүй бол аль нэг хөрөнгө оруулагч дангаараа, эсхүл хэд хэдэн хөрөнгө оруулагч хамтран хөрөнгийн дутууг нөхөх зөрүүг олгож, зохистой харьцааны үзүүлэлтийг шаардлагатай түвшинд хүргэх арга хэмжээг авч болно.

15 дугаар зүйл.Сангийн санхүүгийн тайлан

15.1.Сан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль⁷, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлан гаргана.

15.2.Сан санхүүгийн тайлангаа жил бүр Санхүүгийн зохицуулах хороо, жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

15.3.Сангийн санхүүгийн тайлан нь тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ.

⁷Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 4 дугаарт нийтлэгдсэн.



ЗУРГАДУГААР БҮЛЭГ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

16 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны тавих хяналт

16.1. Санхүүгийн зохицуулах хороо Сангийн өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

16.2. Санхүүгийн зохицуулах хороо энэ хуулийн 16.1-д заасан дүрэм, журмыг батлахдаа жижиг, дунд үйлдвэрийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авна.

ДОЛДУГААР БҮЛЭГ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ДУУСГАВАР БОЛОХ

17 дугаар зүйл. Санг татан буулгах

17.1. Санг Иргэний хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу татан буулгана.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч дараах захиргааны хариуцлага ногдуулна:

18.1.1. Энэ хуулийн 14.2-т заасныг зөрчиж батлан даалт гаргасан бол ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

18.1.2. Тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

18.1.3. Сангийн үйл ажиллагаатай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан тодруулга, мэдээллийг



хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гаргаж өгөхөөс зайлсхийсэн ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

18.1.4.хяналт, шалгалтад саад учруулсан ажилтан, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.1.7 дахь заалт нэмсүгэй:

“3.1.7.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын дугаарыг “3.1.8” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтын “зээлийн баталгаа” гэсний дараа “, батлан даалт” гэж нэмсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 18.1.7 дахь заалт нэмсүгэй:

“18.1.7.зээлийн батлан даалтын байгууллагын хуульд заасан үндсэн үйл ажиллагаанаасаа олсон орлого;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.5.3.зээлийн баталгаа, батлан даалт гаргах, зээлийн батлан даалтын байгууллагад хөрөнгө оруулах, зээлийн батлан даалтын байгууллагын гаргасан батлан даалтыг давхар батлан даах;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 02 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах үйл ажиллагаанд автоматжуулсан систем нэвтрүүлэхтэй холбогдуулан импортоор оруулж байгаа сонгогчийн мэдээллийн санг бүрдүүлж сонгогчийн хувийн мэдээлэлтэй тулган нягтлах, сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах ажиллагааг автоматжуулах зориулалттай харилцан уялдаа бүхий цахим мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжийг 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 02 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах үйл ажиллагаанд автоматжуулсан систем нэвтрүүлэхтэй холбогдуулан импортоор оруулж байгаа сонгогчийн мэдээллийн санг бүрдүүлж сонгогчийн хувийн мэдээлэлтэй тулган нягтлах, сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах ажиллагааг автоматжуулах зориулалттай харилцан уялдаа бүхий цахим мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжийг 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 02 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын 2012 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2012 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/"Монгол Улсын 2011 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

2/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2015 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;

3/"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

4/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт;

5/Монгол Улсын эдийн засаг, нийгмийн болон Засгийн газрын санхүүгийн байдлын талаарх мэдээлэл;

6/"Улсын Их Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

7/Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8/бусад.

2.Энэ тогтоолд зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын 2012 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулахдаа Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэхийг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.



3.Улсын Их Хурлын 2012 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Засгийн газар, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлэг болон Улсын Их Хурлын Тамгын газарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 02 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар
хот

Бор-Өндөр сум байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь хэсэг, Хэнтий аймгийн Бор-Өндөр хотын иргэд, Дархан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Монгол Улсын Засгийн газрын саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн Дархан сумаас тус сумын 5 дугаар баг бөгөөд Бор-Өндөр хотыг тусгаарлаж, шинээр Бор-Өндөр сум байгуулж, төвийг нь Бор-Өндөрт байхаар тогтоосугай.

2.“Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын хилийн цэс”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Хэнтий аймгийн Дархан сумын хилийн цэс”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зарим хот, хороодыг сумдад нэгтгэх тухай” Улсын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 36 дугаар тогтоолын 1 дэх заалтын 17 дахь дэд заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4.“Нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай” БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 75 дугаар зарлигийн сумдын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг баталсан 2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах асуудлыг судалж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



Монгол Улсын Их Хурлын 2012 оны 15 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ХИЛИЙН ЦЭС**

Д/д	Газрын нэр	Өндрийн тоот	Уртраг	Өргөрөг
1	Далан түрүүний булгийн хойт хүүхдийн хөшөөтэй толгой	1292.6	109°19'43"	46°11'48"
2	Өлгий уул	1617.7	109°18'50"	46°18'10"
3	Бумбат уул	1506.7	109°21'12"	46°18'03"
4	Сөдөнгийн ухаа овоот	1377.2	109°24'07"	46°17'50"
5	Эрээн таван тоот	1340.8	109°25'38"	46°18'18"
6	Уушгийн зүүн толгой	1302.4	109°28'18"	46°17'22"
7		1271.4	109°28'45"	46°16'16"
8		1313.5	109°28'49"	46°13'29"
9		1231.1	109°28'15"	46°10'28"
10		1276.8	109°24'20"	46°11'20"
11	Далан түрүүний амралтын баруун хойт овоотой толгой		109°21'7"	46°12'5"
12	Далан түрүүний булгийн хойт хүүхдийн хөшөөтэй толгой	1292.6	109°19'43"	46°11'48"

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 15 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ХИЛИЙН ЦЭС**

Д/д	Газрын нэр	Өндрийн тоот	Уртраг	Өргөрөг
1	Зараа булан		108°57'12"	46°58'13"
2	Хэрлэн голын урд эргээр уруудаж, Дээд хатан хошуу	/1184.4/	109°15'29"	46°56'48"
3		1191.1	109°16'15"	46°56'42"
4	Хүнт нуурын баруун хойт эрэг дэх	/1136.6/	109°16'35"	46°54'35"
5	Ар шанд худаг		109°20'20"	46°48'08"
6	Хуцын хэц	/1307.7/	109°24'45"	46°48'14"
7	Нарийн нуурын урд үзүүр		109°32'20"	46°45'35"
8	Босгын нуурын зүүн үзүүр		109°41'00"	46°39'53"
9	Талын худаг		109°44'18"	46°37'38"
10	Эрэгнэг худаг		109°50'50"	46°37'09"



11		1298.0	109°55'00"	46°37'24"
12	Балцангийн хар өндөр		110°01'45"	46°37'51"
13	Цагаан өндөрийн овоо	/1389.7/	110°02'23"	46°30'37"
14	Хаяа худаг		110°04'19"	46°29'43"
15	Зүрх овоо	/1368.9 /	110°01'30"	46°26'12"
16	Дэрсэн усны худаг		110°01'10"	46°21'20"
17	Дунд мандал овоо		109°57'25"	46°16'47"
18	Нөмрөг		109°57'25"	46°16'47"
19	Баруун мандал овоо	/1228.3/	109°52'29"	46°14'10"
20	Үнэгтэйн гашууны булаг		109°41'30"	46°10'45"
21	Үнэгтэйн худаг		109°32'27"	46°10'23"
22		1231.1,	109°28'15"	46°10'28"
23		1313.5,	109°28'49"	46°13'29"
24		1271.4,	109°28'45"	46°16'16"
25	Уушгийн зүүн толгой	1302.4,	109°28'18"	46°17'22"
26	Эрээн таван тоот	1340.8,	109°25'38"	46°18'18"
27	Сөдөнгийн ухаа овоот	1377.2,	109°24'07"	46°17'50"
28	Бумбат уул	1506.7,	109°21'12"	46°18'03"
29	Өлгий уул	1617.7,	109°18'50"	46°18'10"
30	Далан түрүүний булгийн хойт хүүхдийн хөшөөтэй толгой	1292.6,	109°19'43"	46°11'48"
31	Холбоо	/1529.1/,	109°09'00"	46°19'27"
32	Идэр майхан	/1500.2/,	109°11'23"	46°20'03"
33	Дэвтээрийн овоон шанд	/1597.0/,	109°09'51"	46°23'47"
34	Хараат	/1411.7/,	109°03'15"	46°25'59"
35	Цайдам нуурын хойт үзүүр		109°01'15"	46°30'17"
36	Яргайн өндөр	/1545.3/,	109°02'35"	46°33'44"
37	Дэндгэр шарга		109°03'00"	46°34'19"
38		1353.7	109°02'25"	46°36'49"
39	Хөтөл		109°02'30"	46°42'41"
40	Зүүн овоот	/1306.0/	109°03'29"	46°43'38"
41	Замын шанд		109°03'44"	46°44'27"
42	Хөл нуурын зүүн булан		109°05'50"	46°50'00"
43	Цагаан толгой		109°07'10"	46°51'50"
44	Сүмт овоо		109°05'59"	46°52'50"
45		1261.7,	109°03'34"	46°51'52"
46		1245.7	108°57'04"	46°50'13"
47	Зараа булан		108°57'12"	46°58'13"



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 02 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтад дор дурдсан агуулгатай “г” заалт нэмсүгэй:

“г” Монгол Улсын 2012 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дэх заалтын 9 дэх дэд заалтын дагуу Засгийн газар иргэдээс худалдаж авсан хувьцааны тоогоор энэ тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “в” заалтад заасан хувь, хэмжээг нэмэгдүүлэн тогтоох.”

2. “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “а” заалтын “10 хувийг” гэснийг “20 хүртэлх хувийг” гэж, мөн заалтын 2 дахь дэд заалтын “б” заалтын “хувьцааны 10 хувийг” гэснийг “хувьцааны 10 хүртэлх хувийг” гэж, мөн заалтын 2 дахь дэд заалтын “в” заалтын “30 хүртэлх хувийг” гэснийг “20 хүртэлх хувийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 02 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19¹.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19^{1.5}-д заасан эхэд сар тутам олгох тэтгэмжийн хэмжээг 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 32500 /гучин хоёр мянга таван зуун/ төгрөгөөр, 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 40000 /дөчин мянган/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

2."Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолын нэрийн "Тэтгэмж, мөнгөн тусламжийн" гэснийг "Мөнгөн тусламжийн" гэж өөрчилсүгэй.

3."Тэтгэмж, мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоолын 1 дэх заалтын "Эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 26000 /хорин зургаан мянган/ төгрөгөөр," гэснийг хассугай.

4.Энэ тогтоолыг Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 02 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

**Нөхөн олговрын доод хэмжээг
шинэчлэн тогтоох тухай**

"Нөхөн олговрын талаар зарим арга хэмжээ авах болон нөхөн олговрын доод хэмжээ тогтоох тухай" Улсын Их Хурлын 1999 оны 24 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Тэтгэвэр нь түр зогсоогдсон иргэдэд олгож байгаа нөхөн олговрын доод хэмжээг 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сард 140300 /нэг зуун дөчин мянга гурван зуун/ төгрөгөөр, 2012 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сард 162000 /нэг зуун жаран хоёр мянган/ төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нөхөн олговрын доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 53 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



3.Энэ тогтоолыг Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 02 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

**Засгийн газрын үнэт цаас гаргахыг
зөвшөөрөх тухай**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн алдагдлыг нөхөх, төсвийн цаг зуурын хүндрэлийг даван туулахад зориулан 300.0 /гурван зуун/ тэрбум хүртэлх төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг 2012 оны төсвийн жилд гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 370

Улаанбаатар
хот

**“Өндөр технологийн аж үйлдвэрийг
хөгжүүлэх хөтөлбөр” батлах тухай**

Улсын Их Хурлын 2010 оны 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 1 дүгээр, уг хөтөлбөрийн нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн



төсвийн төсөлд тусгаж, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. “Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2011 оны 370 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэлд “экспортын баримжаатай, хувийн хэвшилд түшиглэсэн өндөр технологид, үүний дотор мэдээлэл, харилцаа, био, нанотехнологи, транзит тээвэр, логистик, санхүүгийн зуучлалын үйлчилгээ, уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гүн боловсруулахад суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоно” гэж заасан бөгөөд 2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжинэ гэсэн зорилтыг тавьсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2010 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 4.2.1.5-д “Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний, салбарын, бүс нутгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан.

Монгол Улсад өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд мэргэшсэн ажиллах хүчин хомс, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрүүдийн хамтын ажиллагаа сул, аж үйлдвэрийн баримжаатай орчин үеийн судалгааны төв, лаборатори байхгүй, хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.



Иймд дээрх тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, Монгол Улсад Өндөр технологийн аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх үндэс суурийг тавих зорилгоор “Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр” (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Байгалийн баялаг, түүхий эдийн нөөц зэрэг харьцангуй давуу тал дээр суурилан орчин үеийн дэвшилтэт техник, технологийн ололтыг нэвтрүүлсэн, дотоодын эрэлт хэрэгцээг хангаж чадах өндөр технологийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг бий болгох, энэ чиглэлийн сургалт, судалгаа, технологи, санхүүгийн дэд бүтцийг цогцоор нь байгуулах замаар Монгол Улсад өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх, эдийн засгийн төрөлжилт бий болгоход энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ.

3.1. Өндөр технологийн аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх:

3.1.1. гадаадын нэр хүнд бүхий судалгаа, шинжилгээний байгууллагуудад ажиллаж буй шилдэг эрдэмтэн, судлаачдыг татах, мэдээллийн технологи болон биотехнологийн салбарын үйлдвэрүүдтэй холбоо тогтоох боломжийг бүрдүүлэх, тэдгээрийг эх орондоо энэ чиглэлийн үйл ажиллагаа эхлүүлэн явуулахад нь дэмжлэг үзүүлэх;

3.1.2. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан мэдээллийн технологи, биотехнологийн салбарын дэлхийн тэргүүлэх их, дээд сургуулиудад улсын зардлаар болон бусад эх үүсвэрээр оюутан сургах;

3.1.3. мэдээллийн технологи, биотехнологийн салбарт гадаадад ажиллаж байгаа дотоодын мэргэжилтэй ажиллах хүчнийг эх орондоо ирж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.4. энтерпренёр төвийг их сургуулиуд дээр байгуулах, энтерпренёр сургалтын хөтөлбөр боловсруулах асуудлыг судалж шийдвэрлэх.

3.2. Өндөр технологийн аж үйлдвэрийн дэд бүтцийг хөгжүүлэх:

3.2.1. биотехнологи болон мэдээллийн технологийн чиглэлээр орчин үеийн судалгаа, шинжилгээ хийх үндэсний судалгааны төв байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;



3.2.2. төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан бүс нутгуудад мэдээлэл, харилцаа холбооны болон эм, био бэлдмэлийн үйлдвэрлэлийн шинжлэх ухаан технологийн парк байгуулах, техник, эдийн засгийн судалгаа хийх;

3.2.3. өндөр технологийн салбарын хөрөнгө оруулалт, технологи, аж ахуйн нэгж, судалгаа, шинжилгээний байгууллага, хүний нөөцийн түвшин, эрдэм шинжилгээний бүтээл, патентын төрөлжсөн мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн сан байгуулах.

3.3. Өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих:

3.3.1. Хөгжлийн банк болон Засгийн газрын тусгай сангуудын хөрөнгө оруулалтаас тэргүүн ээлжинд өндөр технологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл, санхүүгийн түрээс олгох асуудлыг шийдвэрлэх;

3.3.2. олон улсын дэвшилтэт стандартууд (GMP, GLP, GCP)-ыг өндөр технологийн компаниудад нэвтрүүлэх, нутагшуулах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.3.3. өрсөлдөх чадвар бүхий өндөр технологийн бүтээгдэхүүнийг төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд тэргүүн ээлжинд хамруулах замаар борлуулалтыг дэмжих;

3.3.4. зах зээлд шинэ, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн өндөр технологи, инновацийн төсөлд шинээр байгуулах Венчур болон Инновацийн сангаас хөрөнгө оруулалт хийх, зээлийн баталгаа олгох асуудлыг шийдвэрлэх;

3.3.5. өндөр технологи, инновацийн шилдэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэгчид, судлаачдыг шалгаруулах, урамшуулах арга хэмжээ, үзэсгэлэн худалдааг Инновацийн сан болон Шинжлэх ухаан, технологийн сангаас тогтмол зохион байгуулах;

3.3.6. үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараахь төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл хамаарна:

3.3.6.1. биологийн идэвхит бүтээгдэхүүн: ферментаци, бионийлэгжлийн аргаар гарган авсан эмийн болон оношилгооны бэлдмэл, хүнсний бүтээгдэхүүн;



3.3.6.2. хөдөө аж ахуйн салбарт ашиглагдах био технологи болон генийн инженерчлэлийн технологи ашиглан гарган авсан малын вакцин, эм, биобүтээгдэхүүний үйлдвэрлэл;

3.3.6.3. үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэгцээтэй бүрэн болон хагас автоматжуулалтын технологи;

3.3.6.4. программ хангамжийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аутсорсинг.

3.4. Өндөр технологийн аж үйлдвэрийн санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэх:

3.4.1. өндөр технологи, инновацийн үйл ажиллагаанд чиглэсэн төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх, өндөр технологийн аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор “Өндөр технологи, инновацийн хөрөнгө оруулалтын корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

3.4.2. төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан Венчур хөрөнгө оруулалтын болон Инновацийн сангуудыг шинээр байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх;

3.4.3. шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагааны зардалд улсын төсвөөс Монгол Улсын жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 1,5 хүртэл хувийг төсөвлөн зарцуулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.

3.5. Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх:

3.5.1. өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага,
зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогын зөвлөмж, чиглэл өгөх, зохицуулах чиг үүрэг бүхий Өндөр технологийн бодлогын зөвлөл ажиллана. Зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллага, өндөр технологийн салбарын хувийн хэвшлийн төлөөлөл, их, дээд сургууль, эрдэм, шинжилгээний байгууллага болон бусад байгууллагын төлөөллөөс



бүрдсэн байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.2. Хөтөлбөрийн үе шат бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах, уялдуулах, хяналт тавих үүргийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо хариуцан хэрэгжүүлнэ.

4.3. Өндөр технологийн бодлогын зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шат, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг 2017 он хүртэл 5 жилийн хугацаанд дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2012-2014 он;

Хоёрдугаар үе шат: 2015-2017 он.

5.2. Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд дараахь эх үүсвэрийг ашиглана:

5.2.1. улсын төсөв;

5.2.2. өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийн байгууллагын өөрийн хөрөнгө;

5.2.3. хандивлагч орон, олон улсын байгууллага болон Монгол Улсын иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

5.2.4. хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах шууд бус үр дүн:

6.1.1. үйлдвэрлэл үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэн ашиглах замаар эдийн засгийг инновацийн чиг баримжаатай хөгжүүлэх боломж нэмэгдэх;

6.1.2. төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжих;

6.1.3. шинэ, бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд гарч, Монгол Улсын өрсөлдөх чадвар урт хугацаанд дээшлэх;



6.1.4. хуримтлагдсан оюуны капитал, мэдлэг, технологийг эдийн засгийн эргэлтэд оруулж, бий болсон орлогоос эрдэм шинжилгээний ажилд хөрөнгө оруулах боломж нэмэгдэх;

6.1.5. аж үйлдвэрийн шинэ салбар үүссэнээр хөдөлмөр эрхлэлт сайжирч, өндөр үр чадвартай боловсон хүчний тоо нэмэгдэх.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах шууд үр дүн:

6.2.1. экспортын бүтцэд өндөр технологийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин өсөх;

6.2.2. шинжлэх ухаан технологи, инновацийн салбарын санхүүжилтийн хэмжээ, түүнд хувийн хэвшлээс оруулах хөрөнгө оруулалтын эзлэх хувь нэмэгдэх;

6.2.3. Монголын компани, эрдэм шинжилгээний байгууллагуудын нэг жилд бүртгүүлж байгаа олон улсын болон үндэсний хэмжээнд байгуулсан лицензийн гэрээ бүхий патентын тоо өсөх;

6.2.4. өндөр технологийн салбарт ажиллагсдын тоо, тэдгээрийн дундаж цалин нэмэгдэх;

6.2.5. өндөр технологийн аж үйлдвэрийн салбарын нэг ажилтанд ногдох багаж, тоног төхөөрөмжийн хувийн жин, түүний ашиглалтын хугацаа нэмэгдэх;

6.2.6. олон улсын стандартын дагуу үндэсний шинжлэх ухаан, технологийн статистик, үзүүлэлтийн мэдээллийн нэгдсэн сан бий болох.

Долоо. Хөтөлбөрийн тайлан, хяналт, шинжилгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж, үр дүн, тайланг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж, нийтэд мэдээлнэ.

7.2. Хөтөлбөрийн арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнгийн талаар Өндөр технологийн бодлогын зөвлөлд хагас жил тутамд тайлагнаж ажиллана.

Засгийн газрын 2011 оны 370 дугаар
 тогтоолын 2 дугаар хавсралт

**ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН НЭГДҮГЭЭР
 ҮЕ ШАТАНД (2012-2014 ОНД) ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэлч	Оролцогч	Шалгуур үзүүлэлт, үр дүн	Урьдчилсан байдлаар тооцсон төсөв (төгрөгөөр)
Нэг. Өндөр технологийн аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх					
1.1. Өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт шаардагдах хүний нөөцийн хангамж, эрэлт хэрэгцээний талаар нарийвчилсан судалгаа хийнэ	2012 III улирал	ҮХШХ	БСШУЯ, НХХЯ	Өндөр технологийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг оновчтой тодорхойлох боломж бүрдэнэ	Улсын төсвөөс 10 сая
1.2. Биотехнологи болон хөдөө аж ахуй, програм хангамж, аутсорсингийн чиглэлээр магистр, докторын сургалтад суралцагчдыг тэргүүн ээлжинд сургалтын төрийн тэтгэлэгт хөтөлбөрт 100 хувь хамруулна	2012-2014	БСШУЯ	-	Жил бүр дунджаар тус бүр 10 оюутныг төрийн тэтгэлэг хөтөлбөрт хамруулсан байна	Улсын төсвөөс жил бүр 20 сая, нийт 60 сая
1.3. Дэлхийн тэргүүлэх их, дээд сургуулиудад жил бүр тодорхой тооны оюутныг шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр улсын төсвөөс болон хөрөнгийн бусад эх үүсвэрээр суралцуулна	2012-2014	БСШУЯ	-	Жил бүр дунджаар тус бүр 10 оюутныг гадаадын тэргүүлэх их, дээд сургуульд суралцуулна	Улсын төсвөөс 1 тэрбум, Олон улсын төсөл, хөтөлбөр
1.4. Биотехнологи болон мэдээллийн технологийн салбарын залуу эрдэмтэн, судлаачдыг дэмжих зорилготой пост-докторын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо болон тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлнэ	2012-2014	БСШУЯ	-	Жил бүр 10 залуу эрдэмтэн, судлаачийг тус хөтөлбөрт хамруулсан байна	Улсын төсвөөс жил бүр 200 сая, нийт 600 сая
1.5. Биотехнологи болон хөдөө аж ахуй, программ хангамж, аутсорсингийн чиглэлээр гадаадад ажиллаж байгаа дотоодын мэргэжилтэй ажиллах хүчинг буцаан дуудаж өндөр технологийн салбарт ажиллуулах үйл ажиллагааг дэмжинэ	2012-2014	ЗГХЭГ	ҮХШХ	"Зөгийн үүр" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ	-



1.6. Төр, хувийн хэвшлийн зарчимд тулгуурлан энтрепренёр төвийг их сургуулиуд дээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ. Энтрепренёр сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ	2012-2014	БСШУЯ	ИХ сургуулиуд	Сургалтын хөтөлбөр шинэчлэгдэн, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулан гарааны бизнес эрхлэх мэдлэг, чадвартай ажиллах хүчин нэмэгдэнэ	Улсын төсвөөс 120 сая
Хоёр, Өндөр технологийн аж үйлдвэрийн дэд бүтцийг хөгжүүлэх					
2.1. Төрийн болон төрийн бус байгууллага, өндөр технологийн салбарын хувийн хэвшлийн төлөөлөл, их, дээд сургууль, эрдэм, шинжилгээний байгууллага болон бусад байгууллагын төлөөлөөс бүрдсэн "Өндөр технологийн бодлогын зөвлөл"-ийг байгуулж ажиллуулна	2012-2014	ҮХШХ	Яам, Засгийн газрын агентлаг	Үндэсний зөвлөлийг байгуулж үйл ажиллагааг эхлүүлнэ	
2.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан Сэлэнгэ аймагт эм, био бэлдмэлийн, Дархан-Уул аймагт мэдээллийн технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, парк байгуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ	2012-2014	ҮХШХ	ХХААХҮЯ, МШХХТГ	2014 онд багтаан эдгээр паркуудыг байгуулах төслийн урьдчилсан болон техник эдийн засгийн суурь судалгааг гүйцэтгэсэн байна	Улсын төсвөөс 1 тэрбум
2.3. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиудыг түшицлэн "Өндөр технологийн үндэсний судалгааны төв" байгуулах асуудлыг судална	2012-2013	БСШУЯ	ҮХШХ, их, дээд сургуулиуд	Үндэсний судалгааны төвийг байгуулах эрх зүйн үндэсийг бий болгох санал боловсруулж, хөрөнгө оруулалтын төслийн урьдчилсан судалгааг хийсэн байна	Улсын төсвөөс 2.5 тэрбум
2.4. Өндөр технологийн салбарын хөрөнгө оруулалт, технологи, хуулийн этгээд, судалгаа шинжилгээний байгууллага, хүний нөөцийн түвшин, эрдэм шинжилгээний бүтээл, патентийн талаар төрөлжсөн мэдээллийг агуулсан мэдээллийн нэгдсэн сан байгуулна	2012-2013	ҮХШХ	МШХХТГ	Өндөр технологийн салбарын хөгжлийн түвшинг тодорхойлох мэдээллийн цогц сан бий болсон байна.	Улсын төсвөөс 50 сая

2.5. Судалгааны ажлын үр дүнг арилжаалах, шинэ бүтээлийн патентийг лицензийн гэрээгээр ашиглуулах, зуулах үйл ажиллагааг дэмжих ажиллана	2012-2014	БСШУЯ	ОӨГ	Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын бий болгосон оюуны бүтээл, судалгааны ажил эдийн засгийн эргэлтэд орох боломж нэмэгдсэн байна	-
2.6. Шилэн кабелийн дамжуулах систем, мэдээлэл холбооны дэвшилтэт судалгааны лаборатори байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ	2012-2013	БСШУЯ	ШУТИС	Мэдээлэл, холбооны салбарын эрдэмтэн, судлаачдын судалгааны ажлын чанар дээшилж, эрдэмтэн, судлаач, инженер, техникийн ажилчид нэмэгдэх, өндөр технологийн туршилт гүйцэтгэх орчин сайрсах боломж бүрдсэн байна	Улсын төсвөөс 692 сая
Гурав. Өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих					
3.1. Хөгжлийн банкнаас өндөр технологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ	2012-2014	Хөгжлийн банк, ҮХШХ	-	Өзэлгэн эрсдэл болон эргэн төлөгдөх хугацаа, баталгаанд үндэслэн экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төсөлд зээлийн баталгаа олгох эсэх асуудал шийдвэрлэгдсэн байна	Нийт 15 тэрбум Хөгжлийн банкнаас 2012 онд 5 тэрбум 2013 онд 5 тэрбум 2014 онд 5 тэрбум 15 тэрбум
3.2. Өндөр технологи, инновацийн шилдэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэгч, судлаач-бүтэц шалгаруулах, урамшуулах арга хэмжээ болон үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулна	2012-2014	ҮХШХ	МҮХАУТ	2 жилд нэг удаа өндөр технологийн үндэсний хэмжээний үзэсгэлэн яармагийг зохион байгуулсан байна	Улсын төсвөөс 40 сая
3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах замаар өрсөлдөх чадвар бүхий дотоодод үйлдвэрлэсэн өндөр технологийн бүтээгдэхүүний борлуулалтыг бодлогоор дэмжих асуудлыг судалж шийдвэрлэнэ	2012-2014	ҮХШХ	Яам, Засгийн газрын агентлаг	Биотехнологи болон мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүнийг дотоодын худалдан авалтаар дэмжих бодлогыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ	-
3.4. Засгийн газраас НҮБ, ЮНЕСКО, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Европын Холбоотой хамтран хэрэгжүүлж байгаа хөгжлийн буцалтгүй тусламж хөтөлбөр, төслүүдэд өндөр	2012-2014	ҮХШХ	-	Биотехнологи, мэдээллийн технологийн салбарын компанийн удирдлага, менежментийг сайжруулах, шилдэг туршлагыг нэвтрүүлэх	-



технологийн компаниудыг зүүлэх, инновацийн шагналд нэр дэвшүүлэх боломжийг эрэлхийлж ажиллана				ажилд тодорхой ахиц гарсан байна	
3.5. Өндөр технологийн үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл, лиценз, патент худалдан авах зардлыг хэсэглэн санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ	2012-2014	ҮХШХ	СЯ, ОӨГ, ИХ сургуулиуд	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл, патент, лиценз ашиглан, технологи, ноу-хауг нутагшуулах замаар үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж нэмэгдэнэ	200 сая
3.6. Өндөр технологийн бүтээгдэхүүний олон улсын чанар баталгаажуулалтын зардлыг хэсэглэн санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ (GMP, GLP, GCP, ENSO)	2012-2014	ҮХШХ	-	Олон улсын чанар, стандартаар баталгаажсан үндэсний өндөр технологийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, компанийн тоо хэмжээ өснө	200 сая
